



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 8/02

Улаанбаатар хот

Г Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллах
тээврийн хэрэгслийн тоог зохицуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын дүрмийн 2.5.3, 2.5.9 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж буй тээврийн хэрэгслүүдийн техникийн бэлэн байдлын түвшинг сайжруулах, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зорилгоор үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн тоог зуны улиралд бүртгэлийн санд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 80 хувь, өвлийн улиралд 85 хувиас хэтрүүлэхгүй байхаар тогтоож, 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Үйлчилгээнд ажиллаж байгаа тээврийн хэрэгслийн тоог тогтоосонтой уялдуулан тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын үйлчилгээнд ажиллах цагийн хуваарь, нэгдсэн даалгаврыг боловсруулж батлуулахыг Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс /Д.Галбадрах/-т, чиглэлүүдийн өдөр тутмын үйлчилгээг батлагдсан даалгаврын дагуу зохицуулан зохион байгуулж, шуурхай зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Б.Эрдэнэболд/-т, техникийн бэлэн байдал болон шугам замд хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /З.Цэвээндорж/-т тус тус даалгасугай.

3. Тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдал, үйлчилгээний хэвийн ажиллагааг ханган ажиллахыг нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Дээрх тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын 2013 оны “Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн тоог зохицуулах тухай” А/38, 2014 оны “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” А/98 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Х.Булгаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ОТГОНБААТАР



D:\alban khereg\Явсан бичиг-2019\TUSHAAL.docx

1115108253 д. 2117428

1150500021